



ХЭНГИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/39

Бэрх хот

Хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотод үерийн усны суваг, сувагчлал татах, газар шорооны ажил хийх явцад хот дотуур татсан шилэн кабелиг гэмтээж тасалсан тул засварлах ажилд шаардагдах 500,000 төгрөгийг зарцуулсугай.
2. Шаардагдах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг Захирагчийн эрсдлийн сангаас холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гаргахыг Нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАГЧ  Ч.ЭНХЖАВХЛАН

232501039